



# ЦАГААН НЭГ АНГИЙНХАН ТОЛГОЙ



2017-2018 оны хичээлийн жилд цоо шинээр зохиогдон гарч буй “НЭГ АНГИЙНХАН - ЦАГААН ТОЛГОЙ” бол сургалтын цогц хэрэглэгдэхүүн юм.

Учир нь энэ бол дан ганц сурах бичиг биш, түүнийг

- Дасгал ажлын ном
- Үсгийн карт
- Хичээнгүй бичиг, чээж бичгийн дэвтэр
- Багшийн гарын авлага дагалдана.



Цагаан толгойг сурсны дараах шатанд зориулж уншиж сурахад чиглэсэн, түвшин бүрээр ахих унших бичгүүд тус цагаан толгойг залгуулан гарна. Түүнчлэн тус цагаан толгой нь “Нэг ангийнхан - Математик”, “Улирлууд” зэрэг цогц хэрэглэгдэхүүнүүдтэй холбогдоно. Холбогдох сурах хэрэглэгдэхүүнүүд хоорондоо босоо, хэвтээ залгамж холбоотой, дээшлэх түвшингээр спирал хэлбэрээр ахисан цуврал байна.

Ингэж судлагдахуун дотроо болон судлагдахуун дамнан босоо, хэвтээ залгамж холбоог хангаснаар хүүхдийн сурах үйл системтэй, салангид, нэг хэвийн биш, сонирхолтой байх болно.

## ТУС ЦАГААН ТОЛГОЙН ДАВУУ ТАЛ

### Эхүүд

Цагаан толгойн өмнөх үеэс эхлээд үсэг бүрийг таниулах зорилготой эхүүд бий. Тэдгээр эх нь таниулах үсгийнхээ онцлогийг харуулсан, амьдралаас улбаалсан агуулгатай, хүүхдэд танил, энгийн үг хэллэгтэй, хүүхдийн нас сэтгэхүй, сонирхолд нийцсэн.



Салхины чимээг дуурайж хэлцгээе.



Эхүүд нь зөвхөн авиа, үсэгт захирагдахгүй, салангид биш. Сурах бичгийг дэлгэхээс эхлээд үзэж дуустал нэг ангийн хүүхдүүд, тэдний хичээл сургууль, гэр бүлийнхний тухай өгүүлнэ. Ингэснээр нэгж авиа, үсгийг таниулах хичээл, үйл ажиллагаанууд хоорондоо холбогдож, хичээл хоорондын залгамж холбоо хангагдана.

## Нээлттэй

Түүнчлэн энэхүү сурах бичигт нээлттэй байх зарчмыг баримталсан. Энэ нь, үүнийг цагаан толгой анхлан сурч буй 1-р ангид үндсэн сурах бичиг болгож ашиглахаас гадна, уншиж сурсан 2, 3 дугаар ангид ч дасгалууд болон эхийг нь хэсэгчлэн авч ашиглаж болно гэсэн үг. Тус сурах бичиг нь дасгал бүрийг эхнээс нь дуустал дараалан хийх шаардлагад баригдаагүй.

Түүнчлэн улс даяар ашиглаж буй албан ёсны цагаан толгойн сурах бичигт нэмэлт хэрэглэгдэхүүн болгож, дасгал даалгаврыг нь баяжуулан ашиглах боломжтой.

## ЗААХ АРГАЗҮЙН ОНЦЛОГ

Тус цагаан толгойн заах аргазүй нь дараах онцлогтой.

Үүнд:


- Үсгийн санг ашиглах
- Бичиж сурах үйлийг дэмжих
- Бага ангийн хүүхдийн насны онцлогийн дагуух эхийн үндсэн шаардлагыг хангах
- Хичээл төлөвлөлт, дасгал даалгавар боловсруулалтад "Заах аргазүйн анализын загвар"-ыг баримтлах.

Дээрх зарчмуудыг баримталсны учир нь: Бичиг үсэг сурах бол хүнд байгалиас заяасан, төрөлхийн зөн совингоороо хийчих үйл биш. Харин зохиомол, хийсвэр үйл тул оюуны ихээхэн хүч шаарддаг. Томчууд бидэнд амархан санагддаг боловч хүүхдэд бол хийсвэр, хүнд үйл. Дөнгөж сургуульд орж, сурч эхэлж буй хүүхдүүдэд сурах үйл нь хялбар дөхөм, зугаатай, хоорондоо учир холбогдолтой байх нь хамгаас чухал. Тиймээс тэдгээрт аргазүйн хувьд онцгойлон анхаарсан.




Цагаан толгойг анхлан сурч буй хүүхдүүд үсгийн сангийн тусламжтайгаар анхнаасаа л бие даан уншиж, бичиж суран, түүгээрээ бичиг үсгийн үүрэг функцийг амархан ойлгодог.

Тиймээс энэхүү цагаан толгойд үсгийн санг ашиглаж уншиж сурах олон дасгал ажилбар бий.



Үсгийг цэгийн дагуу томоос жижгэрүүлж бичсэний дараагаар шугам дээр бичиж сурна.



### Дасгал даалгаврын бүрэн боловсруулалт

Хичээл төлөвлөлт, дасгал даалгавар боловсруулалтад “Заах аргазүйн анализын загвар”-ыг баримталснаар хичээл зохион байгуулалтын бүх үе шат бүрэн бөгөөд тохирох дасгал даалгавруудтайгаар төлөвлөгдсөн. Дасгал даалгаврууд нь хөнгөнөөс хүнд, хаалттайгаас нээлттэй гэхчилэн бүтээлч түвшин хүртэл иж бүрэн байх тул нэгж үсгийг заахад нэмэлт материал шаардахгүй.

Ингээд “Нэг ангийнхан Цагаан толгой”-г ашиглах та бүхэнд баяр баясал, эрч хүч, шинэ санаа оргилж байхыг хүсье.



**Дидо**  
СУРАХ-СУРГАХ  
ХЭРЭГЛЭГДЭХҮҮН



info@monsudar.mn



www.monsudar.mn



75850724-209



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Амарын гудамж-2, “Адмон принтинг”  
ХХК-ны байр.